



**МОНГОЛ УЛСЫН
БОДЛОГЫН
ЗӨВЛӨМЖҮҮД
ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЛБАРТ ТУЛГАРЧ
БУЙ СОРИЛТ БА
БОЛОМЖ**

2024 он



**МОНГОЛ УЛСЫН БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖҮҮД
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ
ТУЛГАРЧ БҮЙ СОРИЛТ БА БОЛОМЖ**

МОНГОЛ ДАХЬ АМЕРИКИЙН ХУДАЛДААНЫ ТАНХИМ

Зохиогчийн эрх © Энэхүү бодлогын баримт бичгийг Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) Бодлого хариуцсан захирал Г.Жавхлантөгсийн удирдлага дор боловсруулсан болно.

Бодлогын баримт бичгийг бүтнээр, эсвэл хэсэгчлэн дахин хэвлэхэд АмЧам-аас зөвшөөрөл авна.

ЕРӨНХИЙ ТОЙМ

АмЧам Монгол нь эдийн засгийг төрөлжүүлэхэд хөдөө аж ахуйн салбар чухал үүрэг гүйцэтгэх боломжтой гэж үздэг.

Монголын хөдөө аж ахуйн салбар нь бусад салбараас харьцангуй давуу талтай бөгөөд хөрөнгө оруулагчид болон экспортлогчдод боломж олгодог ч хөдөө аж ахуйн санхүүжилтийн боломж, хууль эрх зүйн зохицуулалт, зах зээлийн хүртээмж, эдийн засгийн цар хүрээ зэрэг сорилттой тулгардаг.

Тус баримт бичгийг боловсруулахдаа АмЧамын Хөдөө аж ахуйн хорооны гишүүд, Азийн Хөгжлийн Банк (АХБ), Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК) зэрэг олон улсын байгууллагуудтай хийсэн уулзалтууд, тус салбарын чиглэлээр хийсэн судалгааны материал зэргийг ашигласан болно.


Энэхүү баримт бичигт гадаадын хөрөнгө оруулалт татах боломжтой Монгол улсын хөдөө аж ахуйн дэд салбаруудад дүн шинжилгээ хийж, гадаадын компани, хөрөнгө оруулагчдад хэрэгтэй зөвлөмжүүдийг тусгасан болно.



Монгол Улсын эдийн засагт хөдөө аж ахуйн салбар чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд ДНБ-ий 13 хувь, нийт ажиллах хүчний 30 хувийг тус тус бүрдүүлдэг. АХБ-ны судалгаагаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний 84.2 хувийг мал аж ахуй эзэлж байна. Одоогийн байдлаар мал аж ахуйн салбарын үндсэн түүхий эд болох мах, сүү нь мал аж ахуйн бүтээгдэхүүний 61 хувь, ДНБ-ий 7 хувийг эзэлж байна¹.

Махны үйлдвэрлэл, тэр дундаа махны экспорт нь Монгол Улсын эдийн засгийг төрөлжүүлэх гол хөшүүрэг юм. Монгол Улс 2023 оны арванхоёрдугаар сарын байдлаар 70 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон бөгөөд үүний 40 хувийг БНХАУ-д дулааны аргаар боловсруулсан мах, харин 11 хувийг үхрийн мах, 36 хувийг адуу, 20 хувийг хонь, 33 хувийг ямааны мах тус тус эзэлж байна². Гэхдээ энэ тоо нь манай улсын 70 гаруй сая малтай харьцуулахад харьцангуй бага үзүүлэлт юм.

Экспортлосон махны хувь хэмжээ /%/



Дотоодын сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах боломж бага хэвээр байна. Сүүний үйлдвэрлэл 2020 онд 859,002 мянган тонн байсан бол 2022 онд 990,401 тонн болж, 15 хувиар өсчээ³. Түүнчлэн Монгол орны алсмагдмал байдлаас хамааран сүүг муутгахгүйгээр тээвэрлэхэд хүндрэлтэй байдаг.

¹ Economic analysis. ADB.

² 70 мянган тонн мах экспортолсны 86 хувийг Хятад руу гаргажээ | News.MN

³ Mongolia Production of milk, 1961-2023 - knoema.com

Монгол Улсын Засгийн газраас эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөр болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Хүнсний Хангамж, Хүнсний Аюулгүй Байдал” санаачилга нь ард иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, импортын хүнсний хараат байдлыг бууруулах зорилготой.

“Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг 2018 онд баталсан бөгөөд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, мэргэжлийн холбоодыг дэмжих, кластерийн тогтолцоонд шилжүүлэх, өндөр ашиг шимт мал импортлох, нутагшуулах, тэжээл, хүнсний аюулгүй байдлыг хангах, технологи нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг дэмжих юм.

Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр:

- ◆ Сүү боловсруулах үйлдвэрийн хүчин чадал 35 хувиар нэмэгдэнэ.
- ◆ Үржлийн үнээний тоо хоёр дахин, нэг малаас авах сүү, махны гарц 20 хувь, боловсруулсан сүү, махны хэмжээ 30 хувиар нэмэгдэнэ.
- ◆ Шингэн сүүг импортлохгүй, хуурай сүүний импорт 30 хувь, бусад сүүн бүтээгдэхүүний импорт 15 хувиар буурна.
- ◆ Өндөгний импорт 90 хувь, зөгийн балны импорт 70 хувиар буурна.
- ◆ Эрчимжсэн мал аж ахуйн тэжээлийн хангамж 40 хувь, техник, технологийн шинэчлэл 30 хувиар нэмэгдэнэ.

Монгол Улсын Засгийн газраас “Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал - 2030”-ыг 2016 онд баталсан бөгөөд энэхүү баримт бичгийн “Эдийн засгийн тогтвортой хөгжил” хэсэгт хүнсний үйлдвэрлэлд дэвшилтэт технологи нэвтрүүлэх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, аюулгүй, эрүүл хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэлээр хангахыг тусгасан. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэх нь дараахь үр дүнд хүргэнэ. Үүнд:

I үе шат /2016-2020 он/: Үр тариа, төмс, хүнсний ногооны хэрэгцээг дотоод эх үүсвэрээр бүрэн хангаж, хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуйн кластерыг хөгжүүлж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 30 хувь, сүүний 40 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.

II үе шат /2021-2025 он/: Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр хангах, шинжлэх ухааны өндөр түвшний технологи нэвтрүүлж, олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүн гаргах, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 50 хувь, сүүний 60 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.

III үе шат /2025-2030 он/: Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр бүрэн хангах, олон улсын зах зээлд “Монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 70 хувь, сүүний 80 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах.

Хүнсний аюулгүй байдал, боловсруулсан хүнсийг хөгжүүлэх хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хүрэх үр дүн:

| Шалгуур үзүүлэлт | 2014 суурь он | 2020 он | 2025 он |
|--|---------------|---------|---------|
| Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн мах /мянган тонн/ | 16.8 | 100 | 200 |
| Нийт сүү үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний эзлэх хувь | 9 | 30 | 50 |

Монгол Улсын Засгийн газар хөдөө аж ахуйн салбар дахь ГШХО-ийг дараах зорилгоор нэмэгдүүлэхийг зорьж байна. Үүнд:

- ◆ Уул уурхайн салбараас хэт хамааралтай байдлыг багасгахын тулд эдийн засгийг төрөлжүүлэх.
- ◆ Монгол Улс харьцангуй их хэмжээний хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, хүнсний ногоо импортлодог тул дотоодын үйлдвэрлэлийг дэмжих,
- ◆ Нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг дотоодын зах зээлд нийлүүлэх, экспортлох боломжийг судлах.

ХӨДӨӨ АЖ АХУЙН ДЭД САЛБАРЫН ШИНЖИЛГЭЭ

3.1. СҮҮНИЙ САЛБАР

Сүү, сүүн бүтээгдэхүүн нь эдийн засгийн чухал хэсэг хэвээр байна. Уламжлалт Монгол хоолны багагүй хувийг зуны бэлчээрт бэлчээсэн үхрийн сүү эзэлдэг. Хөдөө орон нутагт сүүг олон төрлийн уламжлалт хоол хийхэд ашигладаг бөгөөд удаан хадгалах боломжтой тул өвөл, хаврын улиралд хэрэглэдэг.

Сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр хөдөө орон нутагт байхгүй байгаа нь хот суурин газрын, тэр дундаа нийслэл Улаанбаатар хотын зах зээлийг сүүн бүтээгдэхүүнээр тогтвортой хангахад хүндрэлтэй байдаг. Нийслэл хотод байрладаг АПУ, Сүү, Витафит, ТЭСО зэрэг 4 компани дотоодын зах зээлийн 95 орчим хувийг эзэлдэг ч сүүг малчны хотхоноос авч үйлдвэрлэгч компанид нийлүүлэх хоорондын зай хол, хадгалах багтаамж болон бусад дэд бүтцийн сул хөгжсөн байдал, улирлын чанартай бүтээгдэхүүн зэргээс шалтгаалан сүүний компаниуд үйлдвэрийнхээ хүчин чадлаа бүрэн дүүрэн ашиглаж чаддаггүй.

Дотоодын зах зээлийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах боломжоос гадна Хятад, Орос, Япон зэрэг бүс нутгийн томоохон зах зээлд гаргах боломжтой. Тухайлбал, эрчимжсэн саалийн үнээний аж ахуй, тэжээлийн үйлдвэрлэл, усалгааны технологи зэрэг дэд салбаруудын нэмүү өртгийн сүлжээний хэсэгт хөрөнгө оруулах боломжтой.


Засгийн газар сүү, сүүн бүтээгдэхүүний салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татахын тулд экспорттой холбоотой зохицуулалтын зарим саад бэрхшээл, дэд бүтцийн хөгжилд анхаарах шаардлагатай.

3.2 МАХ БОЛОВСРУУЛАХ

Засгийн газраас жил бүр зохион байгуулдаг мал тооллогын дүнгээр 2022 онд 71.1 сая толгой мал бүртгэгдэж, 2021 оныхоос 3.8 сая толгой буюу 5.6%-иар өссөн үзүүлэлттэй байна. Малын тооллогоор хонь 46 %, ямаа 38.8%, үхэр 7.7%, адуу 6.8%, тэмээ 0.7% тус тус эзэлж байна⁴.

⁴ Mongolia registers a record number livestock - News.MN

2022 оны мал сүргийн бүтэц /хувиар/



Нийт малын 15 сая буюу 20 хувийг дотооддоо хэрэглэж, арьс шир болон бусад хэрэглээний бус бүтээгдэхүүнийг өөр зориулалтаар ашиглаж байна. 2022-2023 онд 12.8 сая толгой мал буюу 387.9 мянган тонн махыг дотоодын зах зээлд нийлүүлж, нийт малын 9.1 хувь буюу 186.0 мянган тонн махыг экспортод гаргахаар төлөвлөжээ⁵.

Монгол Улс КОВИД-19 цар тахал дэгдэхээс өмнөх хоёр жилд буюу 2017-2019 онд 129 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолсон ч цар тахлын хязгаарлалт, ложистикийн хүндрэл, эдийн засгийн тогтворгүй нөхцөл байдлын улмаас 45 хувиар буурч, 2020 онд 38.8 мянган тонн харин 2021 онд 21800 тонн болж буурчээ. 2022 онд 43 аж ахуйн нэгж дэлхийн 10 улсад 16 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн экспортолжээ⁶.

Сүүлийн 3 жилд Монгол Улс дунджаар 2.3 сая толгой мал экспортолсон бөгөөд нийт экспортын 90 гаруй хувийг БНХАУ-д, үлдсэн хувийг Иран, Арабын Нэгдсэн Эмират Улс, Казахстан, Хонгконг руу экспортолж, 146.5 сая ам.долларын орлого олжээ. Монгол Улс голдуу адууг гадаад зах зээлд гаргадаг бөгөөд нийт экспортын 90 хувийг адуу эзэлдэг. Монгол Улс 2022 оны эцсийн байдлаар 50.6 сая ам.долларын мах экспортолжээ. Адууны мах 21 сая ам.доллар, хонь, ямааны мах 7.1 сая ам.доллар, үхрийн мах 463 мянган ам.долларт тус тус хүрсэн бол 17.3 сая ам.долларын 205 мянган тонн дулааны аргаар боловсруулсан мах экспортолжээ⁷.

Монгол улсын махны үйлдвэрлэл 2022 онд өмнөх оныхоос 16 хувиар өсч, 512 мянган тонн болжээ. 2017-2022 оны хооронд махны үйлдвэрлэлийн хэмжээ жил бүр 7.6 хувиар өссөн байна⁸. Өнгөрсөн жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн хөгжил, амьжиргааны түвшин дээшилсэний үр дүнд махан бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байна. Монгол Улсын нэг хүнд ногдох махны хэрэглээ 2022 онд 111 кг-д хүрчээ.

Хэрэглэгчид махаа үндсэн гурван сувгаар худалдан авдаг. **Нэгдүгээрт**, махны наймаачид амьд мал худалдан авч Улаанбаатар хотын ойролцоох мал нядалгааны газруудад төхөөрч төлбөр төлдөг. Дараа нь махыг хүнсний зах дээр хүргэж борлуулдаг.

⁵ Bloomberg TV Mongolia

⁶ Bloomberg TV Mongolia

⁷ PressReader.com - Digital Newspaper & Magazine Subscriptions

⁸ Production of Meat in Mongolia - 2022 - Charts and Tables - IndexBox



Хоёрдугаарт, мах боловсруулах үйлдвэрүүд нийлүүлэлтийн сүлжээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Тэд малчдаас мал худалдан авч, мах нядалгааны цэгт тушаадаг. Эдгээр аж ахуйн нэгжүүд нийслэлийн хүнсний зах, жижиглэнгийн худалдааны төвүүдийг боловсруулсан махан бүтээгдэхүүнээр хангадаг.



Гуравдугаарт, малчид махаа шууд хэрэглэгчдэд борлуулдаг.




Одоо байгаа малын илүүдэл болон Хятад, Орос, Япон руу экспортлох гарц нээлттэй зэргээс шалтгаалан хөрөнгө оруулалтыг махны экспортод оруулах боломжтой бөгөөд хэд хэдэн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Тухайлбал, малын эрүүл мэнд дотоодын борлуулалт, экспортыг хязгаарласаар байна. Дэлхийн Амьтны Эрүүл Мэндийн Байгууллагын гэрчилгээ олгох хоригийг даван туулах шаардлагатай байна. Олон улсын зах зээлд махны тогтвортой нийлүүлэлтийг хангаж чадвал хөрөнгө оруулагчид одоо байгаа боловсруулах хүчин чадлыг (нядалгааны газар, мах боловсруулах үйлдвэр) сайжруулах эсвэл нэмэгдүүлэх хөшүүрэгтэй болно.

3.3. НООЛУУРЫН САЛБАР

Монгол Улс дэлхийн ноолуурын үйлдвэрлэлийн гуравны нэг буюу жилд 8500 тонн түүхий ноолуур үйлдвэрлэдэг. Ноолуур, ноосны салбар Монголын нийт экспортын 34 хувийг бүрдүүлдэг. Ноос, түүхий ноолуурын 15-25 хувийг бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигладаг бол үлдсэн 75 хувь нь угаасан буюу самнасан ноос эзэлдэг бөгөөд Хятад руу экспортолдог. Монгол Улс 2020 онд 6.3 сая тонн угаасан ноолуур, 260 мянган кг самнасан ноолуур, 314 мянган ширхэг нэхмэл бүтээгдэхүүн экспортолжээ.

2020 онд нийт экспортын 84.4 хувийг угаасан ноолуур (185.3 сая ам. доллар) эзэлж байсан бол самнасан ноолуур 7.7 хувийг (16.9 сая ам. доллар), зөвхөн 7.9 хувийг (16.9 сая доллар) сүлжмэл, нэхмэл ноолууран бүтээгдэхүүн тус тус эзэлж байна⁹.

Эцсийн ноолууран бүтээгдэхүүн нь доор үзүүлсэн гурван үе шат дамждаг.



Эх сурвалж: Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам

Эргэлтийн хөрөнгө, орчин үеийн технологи, тоног төхөөрөмж, ноу-хау дутагдалтай байгаа нь ноолуурын салбарын хөгжлийг сааруулсаар байна. Боловсруулалт хангалтгүй, нэмүү өртөг шингээгүйгээс Монгол Улс гадаадын компаниудтай өрсөлдөх чадваргүй болсон.

Ноолуурын эрэлт Европт тогтмол өсч байна. Ноолуурын хамгийн том импортлогчид нь Итали, Их Британи, Япон, АНУ юм. АНУ бол дэлхийн хамгийн том ноолуур импортлогч орон. Дэлхийн ноолууран хувцасны зах зээл 2020 онд 2.79 тэрбум ам.долларт хүрсэн бол 2026 оны эцэс гэхэд 3.66 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна. 2021-2026 онд 3.9%-иар өснө гэсэн тооцоо гаргажээ¹⁰.

Ноолуурын эрэлт сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна. Гэвч энэхүү эрэлт хэрэгцээ нь ямааны сүргийн тоо толгой хэт олширч байгаатай холбоотой бөгөөд энэ нь бэлчээрийн даац хэтэрч, орон нутгийн экосистемийн тогтвортой байдал, нүүдэлчдийн амьжиргаа, мал аж ахуйн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлж байна. Бэлчээрийн даац хэтрэх, уур амьсгалын өөрчлөлт нь Монгол орны газрын доройтол, цөлжилтэд нөлөөлж байна.

Ноолуурын үйлдвэрүүд байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах, малчдын амьжиргааг баталгаажуулах, малын аж ахуйг сайжруулах, нэмүү өртгийн сүлжээний тогтвортой байдлыг хангах үйл ажиллагаанд илүү анхаарч байна. Тухайлбал, "ГОВЬ" компани ноолуурын үйлдвэрлэлийн чиглэлээр 40 шахам жил ажиллаж байна. Тогтвортой Ноос Ноолуурын Эвсэлийн гишүүний хувьд "Тогтвортой Ноолуур" төслөөрөө дамжуулан "ГОВЬ" компани мал аж ахуйг дэмжих, ноолуурын чанарыг сайжруулах, орон нутгийн иргэдийн менежментийг бэхжүүлэх гэсэн харилцан уялдаатай гурван чиглэлээр ажилладаг.

Монгол Улс нь Япон, АНУ, Европын Холбоо, Канад зэрэг улсаас хэрэгжүүлдэг Хөнгөлөлтийн Ерөнхий Систем (GSP) -д нэгдэн орж, тарифын хөнгөлөлт эдэлдэг тул ноолуурын экспортод худалдааны ямар нэгэн саад бэрхшээл байхгүй болно. Тус салбарын боловсруулах үйл явц буюу бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд аутсорсинг болон хамтарсан үйлдвэрийн үйл ажиллагаанд ГШХО татах боломжтой.

3.4. ГАЗАР ТАРИАЛАНГИЙН ТЕХНОЛОГИ, МАШИН

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Яам өөрийн цахим хуудаснаа бараа, үйлчилгээний тендерийн зарыг нийтэлдэг.

Монгол Улсын тендерийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар худалдан авахад шаардлагатай тоног төхөөрөмжийг татвар, гаалийн татвараас чөлөөлснөөс бусад тохиолдолд тоног төхөөрөмжид татвар, гаалийн татвар ногдуулдаг.

⁹ v1115_revised report.pdf (mongolchamber.mn)

¹⁰ CASHMERE INITIATIVES WORKING TOGETHER TO IMPROVE THE VALUE CHAIN | United Nations Development Programme (undp.org)

МОНГОЛ УЛСАД ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ АМЖИЛТТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ БИЗНЕСИЙН САЙН ТУРШЛАГА

MSM Групп - John Deere тоног төхөөрөмж

MSM групп нь 1998 онд Монгол улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд хөдөө аж ахуй, автомашин, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, химийн бодис, ундаа импортлогч зэрэг өргөн хүрээний бизнес эрхэлдэг. MSM одоогоор John Deere компанийн Монгол дахь цорын ганц дистрибьютер юм.

Тус групп нь тус улсын бизнес эрхлэгчдэд зориулсан үйлдвэр, хөдөө аж ахуй, худалдааны тээврийн хэрэгслийн үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор АНУ-ын Олон улсын хөгжлийн санхүүгийн корпорациас 10 сая долларын зээл авч амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

Метагро ХХК

М-Си-Эс группын хөрөнгө оруулалттай Метагро компани үхрийн махны дээд зэрэглэлийн "Primeat" брэндээ зах зээлд нийлүүлж эхэллээ.

Эрчимжсэн мал аж ахуй, ухаалаг газар тариаланг хослуулан хөгжүүлж, олон улсын стандартад нийцсэн чанартай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг өрсөлдөхүйц үнээр дотоод, гадаадын зах зээлд нийлүүлэх зорилгоор 2021 онд байгуулагдсан Метагро компани нь дэлхийд алдартай мал аж ахуй, тэжээл, малын чиглэлээр бизнес эрхэлж байна. Тус компани санхүүжилтээ дотоодын банкнаас гаргаж, АНУ-аас ухаалаг хөдөө аж ахуйн технологи худалдаж авсан.

Тус компани нь хөрс хамгаалах бордоогүй технологи, ургацыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг оновчтой болгох ухаалаг газар тариалан, усалгааны систем, малын эрүүл мэнд, бордооны аж ахуй зэрэг хүнсний аюулгүй байдлын чиглэлээр ажиллаж байна.

Мөн эрчимжсэн мал аж ахуйн цогцолбор нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулж, хүнсний аюулгүй байдлыг хангахад шаардлагатай хөрөнгө оруулалт, техник, технологийн шийдлүүдийг нэвтрүүлж байна.

Говь

Монголын хамгийн том ноолуур үйлдвэрлэгч Говь Корпораци 2019 оны есдүгээр сард Калифорни мужийн Лос Анжелес хотноо "Gobi Cashmere USA" дэлгүүрээ нээж, цахим худалдааны вэб сайтаар дамжуулан АНУ-ын хэрэглэгчдэд бүтээгдэхүүнээ борлуулж байна.

Говь Корпораци одоогоор олон улсын зах зээлд сайн чанарын түүхий ноолууран бүтээгдэхүүн нийлүүлж байгаа ч АНУ-ын зах зээлд Хятадтай өрсөлдөхөд хүндрэл учирч байна. Говь Корпораци Чикаго, Лос Анжелес, Сан Франциско зэрэг хотод франчайзын дэлгүүрүүдтэй.

2023 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт 6 хувиас давсан ч ХАА-н салбар 9 хувиар буурчээ. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарт сорилт, асуудал байгаа ч хөрөнгө оруулагчдад энэ салбарт өрсөлдөхүйц боломж байгаа хэмээн АмЧам Монгол үзэж байна.

Монгол Улсын Засгийн газраас хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх чиглэлээр хүчин чармайлт гарган ажиллаж байна. Засгийн газар байнга солигдож байгаатай холбоотойгоор бодлогын уялдаа холбоо сул байна.

АмЧам Монгол тус салбарыг хөрөнгө оруулалтыг татахуйц болгох бодлогын дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- ◆ АмЧам Монгол нь Монголын хөдөө аж ахуйн салбарт бизнес эрхлэх сонирхолтой Америк болон бусад “гуравдагч хөрш” хөрөнгө оруулагчдад ижил тэгш өрсөлдөөний нөхцөл бүрдүүлэхийг тууштай дэмжин ажилладаг.
- ◆ АмЧам Монгол нь АНУ болон бусад орны зах зээлээс хөдөө аж ахуйн дэвшилтэт технологи, тоног төхөөрөмж, машин механизмыг нэвтрүүлэхэд Засгийн Газраас зохицуулалтын болон татварын хөнгөлөлт үзүүлэхийг уриалж байна. Монгол Улс хөдөө аж ахуйн орчин үеийн шинэ техник, тоног төхөөрөмж нийлүүлэхэд төрийн дэмжлэгтэй санхүүжилт бүхий ойрын хөршүүдийн дарамттай тулгарч байна.
- ◆ Монгол мах, сүүн бүтээгдэхүүнийг экспортод гаргахын тулд хөрш орнуудтай хоёр талын хорио цээрийн дэглэм тогтоох тухай гэрээг байгуулах ажлыг хурдасгах,
- ◆ Монголд хөдөө аж ахуйн бизнесийг амжилттай явуулахад нэмүү өртөгийн сүлжээнд анализ дүгнэлт хийх,
- ◆ Хөрөнгө оруулагчид франчайзинг ба лиценз (жишээлбэл, олон улсын хүнсний сүлжээ), маркетинг, брэнд зэрэгт хөрөнгө оруулах,
- ◆ Махны салбар бол Зүүн Өмнөд Ази, Төв Ази, Ойрхи Дорнодын зах зээлд гаргах экспортын ирээдүйтэй салбар юм.
- ◆ Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, тэр дундаа чацаргана, ингэний сүүг эко цэвэр эцсийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд өргөнөөр ашигладаг эм, гоо сайхны салбарт хөрөнгө оруулах боломж бий.

